



**“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 18 өдөр

№ 01

Дархан уул аймаг

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дахь заалт, “Тээвэр Дархан” ХК-ийн дүрмийн 17.1, 17.5 дэхь заалт, ТУЗ-ийн 2023 оны 2 сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогч гишүүдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 300 төгрөг олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
2. Ногдол ашгийг 2023 оны 12 сарын 31-ны дотор олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
3. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

Хурлын дарга



М.Оюун

**“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 02 сарын 18 өдөр

№ 01

Дархан уул аймаг

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

“Тээвэр дархан” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурал 2023 оны 2 сарын 18-ны өдрийн 13⁰⁰ цагт гүйцэтгэх захирлын өрөөнд эхлэв.

Хуралд Компанийн ТУЗ-ийн дарга Б.Саруул гадаадаас цахимаар оролцож хурал даргалах гишүүнээр компанийн дүрмийн 8.18-т заалтын дагуу “Тээвэр Дархан” ХК-ний гүйцэтгэх захирал М.Оюунаар томилж байгаагаа илэрхийлэв. Гишүүн М.Оюун, М.Жавхлан, Ж.Очирсүх, хараат бус гишүүн Д.Чулуун, Х.Жаргалсайхан нар оролцов. Мөн Гишүүн Ж.Мөнхтөр, Л.Амарсанаа нар хэлэлцэх асуудлыг дэмжиж буйгаа утсаар илэрхийлсэн. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Жавхлантагс хурлын ирц хуулийн дагуу хүрч байгааг танилцуулав.

Ингээд хурлыг нээж хурал даргалагч М.Оюун хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дэхь заалт, компанийн дүрмийн 17.1, 17.5 дэхь заалтын дагуу ТУЗ ногдол ашиг олгох, эс олгох талаар шийдвэрээ гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ёстой.

Хурал даргалагч: Ингээд компанийн гүйцэтгэх захирал, гишүүн М.Оюун ногдол ашиг олгох, эс олгох талаар мэдээлэл өгнө.

2020, 2021 онуудад цар тахалтай холбоотой эдийн засаг, санхүүгийн байдал хүнд байсан тул ногдол ашиг хуваарилах боломжгүй байсан. 2022 оны ногдол ашгийг олгох саналтай байна. Нэгж хувьцаанд ногдох ашгийг урьд онуудад 500 төгрөгөөр олгож байсан. Энэ онд 300 төгрөг болгох саналтай байна.

Хурал даргалагч: “Тээвэр Дархан” ХК-ний ерөнхий нягтлан бодогч Д.Бямбажаргал 2022 оны үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн талаар тайлангаа танилцуулна.

Хурал даргалагч: Та бүхэн тайлантай танилцлаа. Хэлэлцэж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Санал хүсэлт байвал хэлж болно.

ТУЗ-ийн гишүүн Ж.Очирсүх: Ойлгож байна аа. Дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Чулуун: Гүйцэтгэх захирлын саналыг дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн М.Жавхлан: Дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Жаргалсайхан: Дэмжиж байна.

Хурал даргалагч: Миний хувьд дэмжиж байгаа. Та бүхэнд өөр санал байвал хэлж болно. Байхгүй бол хурлаас доорхи тогтоолыг гаргахаар шийдвэрлэж байна. Та бүхэнд танилцуулья. Үүнд:

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дахь заалт, "Тээвэр дархан" ХК-ийн дүрмийн 17.1, 17.5 дэхь заалт, ТУЗ-ийн 2023 оны 2 сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогч гишүүдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 300 төгрөг олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
2. Ногдол ашгийг 2023 оны 12 сарын 31-ны дотор олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
3. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

Хурал даргалагч: Та бүхэн хурлаас гарах тогтоолын төсөлтэй танилцлаа. ТУЗ-ийн гишүүд та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье. Энэ удаагийн ээлжит хурал өндөрлөж байна.

Шийдвэрийг зөвшөөрсөн:

Хурлын дарга:

ТУЗ-ийн гишүүн:



М.Оюун

Ж.Очирсүх

М.Жавхлан

ТУЗ-ийн хараат бус

гишүүн:

Д.Чулуун

Х.Жаргалсайхан

Бумцэрэн

ТУЗ-ийн нарийн

бичгийн дарга

Э.Жавхлантөгс